



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/771

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Байгаль орчноо хамгаалах, байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах, байгаль орчны багц хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн А.Нансалмаа, Б.Мөнхдолгор нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан албан хаагчдад 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Л.Батбаяр/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

